

СОЁЛ

**ТОРГОН ЗЭЭГТ НААМАЛ, МОНГОЛ
ЗУРАГНЫ ШҮТЭЛЦЭЭ****Ү. Дашням**

Зээгт наамал¹ эрт дээр үеэс монголчуудын уламжлан ирсэн гоёл чимэглэлийн бие даасан нэгэн өвөрмөц урлагийн төрөл² билээ. Энэ нь нүүдлийн аж байдалтай улс түмний ахуй нөхцлөөс бүрэлдэн буй болж тээшинд хөнгөн, зай бага эзэлдэг монгол үндэсний уламжлалт гоёл чимэглэлийн урлаг³ болсон юм.

Монгол оронд зээгт наамал урлаг үүссэн цагаасаа урт удаан хугацаанд тодорхой чиглэлээр хөгжихдөө урлан бүтээх арга ухаан, ур чадвар нь үргэлж шинэчлэгдэн боловсорсоор иржээ.

Дундад зууны үеийн гоо зүйн бурангуй сурталчид хувирашгүй үнэн урлаг зөвхөн сүм хийдийн урлаг байх ёстой хэмээн номлож, тэд өөрийн үзэл суртал, ёс суртахууныг сурталчлан дэлгэрүүлэхдээ монгол үндэсний уламжлалт гоёл чимэглэлийн зээгт наамал урлагийг ашиглаж ирсэн түүхтэй.

Манай улсын дүрслэх урлагийн музейн үзмэрт буй монголчуудын зээгт наамал урлагийн уламжлал, гар урлагийн гайхамшигт нарийн ур хийц, тухайн үеийн ахмад урчуудын авьяас чадварыг илтгэсэн олон сайхан бүтээлүүдийг тус орны хөдөлмөрчид, ах дүү орны болон алс холын зочид шагшин сонирхож байдаг билээ.

Өнгөрсөн зууны үед Их Хүрээний зураачдын зураг загвараар тухайн үеийн зээгт наамалчид болох сангай үйлчингүүд хамтран бүтээсэн өнгө тод хурц, уран сайхны хэтрүүлэг, ер бусын хөдөлгөөнтэй, 14 метр урт, өргөн торгон зээгт наамал* бүтээснийг дурьдахад бахдалтай байна.

Энэ урлаг нь өнгийн торго, хоргойгоор урлан бүтээх зүйлээ дүрслэн, түүнийхээ зах хөвөөг нугалан дарж, тэр дүрсийнхээ ирмэг хөвөөг дагуулан зээглэдэг нарийн зурвас торгоор хажлага тавих, зээглэхдээ гурамсан утсаар буюу адууны хялгас торгон утсаар ороож зээглэх, алт мөнгөн саа утсаар ар дэвсгэрт нь даруулан оёдог зэрэг олон ангид төрөлд хувааж болно. Алтан саа утсаар зээглэхдээ улаан утсаар тохож даруулан оёдог нь шар улаан хоёр өнгө туяаран харагдах зохимжтой болдог, мөнгөн сааг ногоон буюу цагаан торгон утсаар даруулдаг журамтай ажээ.

Торгон зээгт наамлыг гол төлөв зураач, зээгт наамалчид хамтран бүтээдэг учраас уран зураач нь дүрслэн бүтээх зүйлийнхээ «хар зураг»⁵

¹ Ү. Ядамсүрэн. «Заагт наамал хийдэг арга ажиллагааны тухай» Дүрслэх урлаг сэтгүүл. УБ., 1974, № 2, 31-р тал.

² Ү. Дашням «Монгольская аппликация»—Современная монголия, УБ. 1968, № 9, 10-р тал.

³ Ү. Дашням. «Дэрфийрармаге махакала». Билденде Күнст, Берлин, 1979, № 7, 329-р тал.

⁴ Ү Дашням. «Музейн танхимаас, Очирваань»,—Дүрслэх урлаг сэтгүүл. УБ., 1976. № 1, 47-р тал.

⁵ Н. Цүлтэн. «Хар зураг».—Дүрслэх урлаг сэтгүүл. УБ., .1974. № 3, 7-р тал.

ийг уран сайхан, гоо зүйн талаас бодон боловсруулж зураг төслийг нь түүнд байвал зохих өнгийн хамт сонгон шийдэж тохируулдаг. Зээгт наамалчид нь тэр өнгөнд тохирох торго, хоргой, торгон утас зэрэг зарцуулагдах бүхий л эд материалаа зураачийн удирдлага, зааврын дагуу феодалын нийгмийн тэр үед торгон бурхан бүтээлгэж байгаа өглөгийн эзнээр бэлтгүүлэн зээгт наамал урладаг тогтсон дэс дарааллын дагуу зээг тавьж торгон зураг бүтээдэг байжээ.

Зээг тавина гэдэг бол торго, хоргой мэт зөөлөн эдлэлээр хийсэн эсгэмэл дүрсүүдийн уул хэв маягийг алдагдуулахгүйн тулд хэрэглэдэг нэг ёсны бэхлэлт юм. Зээг гэдэг нь хонь, тэмээний ноолуур эсхүүл адууны хялгасаар томсон цагаан, хар, хүрэн өнгийн зээгээр өргөө гэрийн дээвэр, туурганы зээг, эсгий үүд, өрхний зах хөвөө, ширмэл ширдэгний болон хаяавч, тэмээний тохош, эсгийгээр хийсэн аяганы уут зэргийн хөвөөг эмжин тавихыг хэлдэг билээ. Ийм арга ажиллагаагаар урлаж зээглэх, гоёж чимэх арга ухаан бол Төв Азийн нүүдэлчин аймгуудын гоёл чимэглэлийн өвөрмөц арга ажиллагаа болох нь МЭӨ Хүннү гүр- ний эртний судлалын олдвороос гарсан Ноён уулын булшны ширмэл ширдэг дээрх зураг,⁶ түүнийг бүтээсэн арга техникээс тодорхой байна. Мөн Жужан⁷ улсын хаанаас Тоба улсын эрх баригчид сувдаар хэлхэж бүтээсэн бурхан бэлэглэж байсан явдал⁸ нь зээгт наамлыг эртний монгол аймагтны уламжлалт гоёл чимэглэлийн гар урлаг болохыг дахин харуулахын хамт эртний буурал өвөг дээдсээс уламжлан ирсэн болохыг нотолж байна.

Дүрслэх урлагийн музейн үзмэрт байгаа шүр, сувд, анар тэргүүтнийг шигтгэн гоёж чимсэн XVII зууны «Охин тэнгэр» торгон зураг бол монгол үндэстний уламжлалт гар урлагийн бас нэг онцлогийг хадгалсан зүйл юм. XX зууны эхэнд VIII Жавзандамба Монгол улсын хэмжээгүй эрхт эзэн хаанаар өргөмжлөгдөхөд урчууд түүний дээлний өнгөний 25 дугуй хээг 94.875 ширхэг шүр, 17.600 ширхэг сувдаар хэлхэж урласан байна. Ийнхүү шүр сувдаар хээ угалз гарган урлах ажлыг Их Хүрээний «Сангай үйлчингүүд» гүйцэтгэж байжээ.

Монголын их хаадын үед ордны хэрэгцээг хангах алтан саа нэхмэлийн улсын чанартай үйлдвэр байжээ. Энэ үйлдвэр Юан гүрний нийслэл Бээжин хийгээд дэд нийслэл Шандун хоёрыг холбосон зам дээр байрлаж байжээ. Тэр үйлдвэрт гол төлөв баруун туркистанаас нүүлгэн авчирсан гурван мянган өрх лалын шашинтангууд ажиллаж байсан гэж зарим эрдэмтэд үзэж байна.⁹

Монголын зээгт наамал урлагийн гоёл чимэглэлд байгаа орчныг дүрслэх явдал шашны сэдэвт хуучин ба орчин үеийн уран бүтээлд нэгэн адил чухал зүйлийн нэг болж байдаг юм. Хуучны урлагийн зураг, зээгт наамалд арга билгийг билэгдсэн, зохих өнгийн будаг буюу торго, хатгамалаар нар сарыг, мөн тодорхой аргаар мандал, цагаан, ягаан үүлс огторгуйд дүрсэлдэг бөгөөд эдгээрийг огторгуйн гурван чимэг гэж нэрлэж ирсэн, мөн түүнчлэн хөрст алтан дэлхийд ус, ургамал, уул хад эдгээрийг газрын гурван чимэг гэдэг. Дээрх зургаан зүйлийг монгол зурагт дүрслэж байсантай нэгэн адил торгон зурагт, ялангуяа хуучны сэдэвт бүтээлд тогтмол урлан бүтээж иржээ.

⁶ Ц. Доржсүрэн. «Умарт Хүннү» УБ.- 1961. ,77-р тал.

⁷ Ц. Хандсүрэн. «Жужаны аж байдал, соёл зан заншлын тухай» Түүхийн судлал, боть VIII, дэвтэр 1 —12, УБ. 1968. 77-р тал.

⁸ Цинь Дин, «Вэй чү ли чуань. (Зарилгаар тогтоосон Тоба Улсын намтар)» (Тэнгэр тэтгэсний 4-р оны хэвлэл). 1874 он, 7-р дэвтрийн 16-р тал.

⁹ Тооруу Сагүчи. «Дорнот өрнөдийн соёл иргэншил, 4-р боть» --Монголын эзэнт улс, баруун европ» 1981, Токио, 252—253-р тал.

Газрын гурван чимэгт дүрсэлсэн дүрс зураас нь хол ойрын алслал илтгэдэг бөгөөд түүнд дүрсэлсэн уул хад нь нэг үйл явдал нөгөө үйл явдалд шилжих ямар нэгэн тодорхой орчныг илтгэх үүрэг гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн торгон зээгт наамалд хэрэглэсэн торгоны өнгөний хүнд хөнгөнөөр хол ойрын алслалыг илтгэдэг монгол зургийн өвөрмөц онцлогийг торгон зээгт наамалд нэгэн адил мөрдлөг болгодог юм.

Зээгт наамалд өнгийн харьцаагаар зохих товгор эзлэхүүн ойлголт төсөөлөлийг илтгэдгийг хар хөх өнгө хийгээд түүний тэртээд бадарсан улаан галын дөл мэт хоёр хүчтэй хүйтэн дулаан нөлөөтэй өнгөөр зээглэн бүтээдэг ажээ.

Торгон зураг нь хэлбэр дүрслэл, хэм хэмжээний хувьд томоос жижигт урлан бүтээгдэж байсан, сүрлэг дайчин хэлбэртэй гоёл чимэглэлийн зүйл юм.

Зээгт наамал, монгол уран зураг хоёр нь хоорондоо маш нарийн шүтэлцээ холбоотой болохыг хэн ч үгүйсгэхгүй. Иймд энэхүү гар урлагийг торгон зураг гэж нэрлэхэд хүргэж байгаа юм. Монгол уран зураг бол зарим талаараа зохих товгор эзлэхүүнтэй, хавтгай биш, өнгөний хүнд хөнгөний байдлаас нэг хэмжээний байдаг учраас уран зургийн нарийн бөгөөд өөрийн өвөрмөц шинжийг хадгалж ширхэгчлэн зураасаар дүрслэж байдаг. Зээгт наамал бол дан ганц хурц тод материалын өнгөөр үйлдэн, хүрээлсэн зураасны оронд зээгээр дүрслэдэгт оршино.

Монгол уран зурагт түүний өнгийг ургамлын гаралтай буюу шороон будаг эсвэл чулуун будгаар гаргаж байсан бол торгон зээгт наамалд эдгээр олон өнгө аясыг торго, хоргой утас гэх мэт торгомсог эсгэмэл материалаар бүтээдгээрээ жирийн уран зурагтай харьцуулахад үзэгчдийн сэтгэл санаанд нөлөөлөх яруу сайхны өнгө үнэмшлээр илүү зохицонгүй болдог билээ.

Монголын уран зурагт шороон, чулуун будагнаас гадна есөн эрдэнэ хэмээх алт, мөнгө, шүр, сувд, оюу, лавай, хув, зэс зэргийг нунтаглан будаг болгон хэрэглэж байсан уламжлалтай. Торгон зээгт наамалд хэрэглэж байсан өнгө нь хоргой торгонд байгаа материалын өнгөөр хэрэгцээг хангахын зэрэгцээ, түүний гоёл чимэглэлд заримдаа алт, мөнгө, шүр, сувд, мөнгөн шүр, анар, номин, оюу, тогосны өд зэргийг хэрэглэдгээрээ уран зурагнаас ялгаатай бөгөөд чухамхүү ийм биет зүйлээр гоёж чимдэгээрээ үзэгчдийн олон давхаргаанд өгөх гоо сайхны таашаалаараа илүү хүчтэй байдаг билээ.

Торгон зээгт наамлын сүрлэг дайчин гоёл чимэглэлийг хамтран бүтээх хөдөлмөрийн үр дүнд зохион бүтээдэг хандлагатай байдаг. Гэхдээ нэгэн хүн урлаж бүтээсэн юм шиг байдаг. Мөн уран зураг шиг харагддаг. Түүнийг маш өндөр мэргэжсэн зээгт наамилчид гүйцэтгэж байжээ. Зээгт наамал нь уран зураг мэт нарийн зүйлүүдийг ширхэгчлэн тэр болгон дүрслэдэггүй боловч үзэгч олон түмний сонирхол, таашаалд тохирсон өнгийн хоршлыг хэрэглэдгээрээ өвөрмөц онцлогтой юм.

Монголын торгон зээгт наамал урлаг нь дорно дахины урлагт монголчуудын оруулсан хувь нэмрийн нэг бөгөөд энэ уламжлалт гоёл чимэглэлийн торгон зээгт наамал нь эдүгээ социалист монголын дүрслэх урлагт зохих байр сууриа эзлэн хөгжсөөр байгааг орчин үеийн зээгт наамлаар уран бүтээл хийдэг урчуудын «Манай эх орон», «Монгол-Зөвлөлтийн найрамдал» бүтээлээс харж болно.

Монголын торгон зураг зарим талаар феодалын нийгмийн үед шарын шашны суртал ухуулгын хэрэглэл, шашин шүтлэгийн зориулалттай гар урлаг байсан бол эдүгээ социалист монголын үед коммунист хүмүүжлийн үүрэг гүйцэтгэдэг, жинхэнэ ард түмний урлаг боллоо. Иймд

торгон зургаар оюун ухаанаа дайчлан бүтээл туурвидаг урчуудаас урлагийн гавьяатнууд төрөн гарч байгаа нь орчин үеийн торгон зургийг нам, засгаас зохих ёсоор анхааран үзэж байгаагийн тод илрэл юм.

Монголын ард түмний уламжлалт гоёл чимэглэлийн зээгт наамал урлагт хурц тод улаан, хөх, ногоон өнгүүдийг чадалтай хоршуулан хэрэглэж ирсэн нь даруй үзэгч түмний ахуй амьдралд ундарсан мөнхийн шинэ хүчин зүйлийн тусгал, дээд зэргийн гоо зүйн шинж гэлтэй.